

## “МОНГОЛ ДАХЬ ЯПОН СУДЛАЛ” СИМПОЗИУМ

*Ж.Уянга\**

Энэ 2007 он нь Монгол-Япон улс дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ойн жил бөгөөд Монгол дахь Японы жил тохиож байгаа билээ. Энэхүү ойн арга хэмжээг тохиолдуулан “Монгол дахь Японы жил”-ийг зохион байгуулах Хороо, ШУА-ын Олон Улс Судлалын Хүрээлэн, Монгол Улс дахь Япон улсын Элчин Сайдын Яам, Монгол, Японы төвөөс хамтран “Монгол дахь Япон судлал” сэдэвт симпозиумыг 2007 оны 1-р сарын 19-ний өдөр Улаанбаатар хотноо Монгол-Японы төвд зохион байгууллаа. Энэ симпозиум нь Япон судлалыг эрхэлдэг бүх салбарын судлаачид, эрдэмтэд, Засгийн Газар, найрамдлын нийгэмлэг, олон нийтийн байгууллагын төлөөлөгчид, их дээд сургуулийн япон судлалын багш, оюутнууд, жирийн иргэд оролцсон томоохон хэмжээний симпозиум болсон бөгөөд энэ симпозиумаар тэмдэглэлт ойн жилийн үйл ажиллагааг нээснээрээ онцлогтой юм.

Япон улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Ичихаши Ясүёши сэтгэгдлээ хэлж симпозиумыг нээсэн билээ. Тэрээр “Симпозиум зохион байгуулагдсан өдөр ердийн ажлын өдөр байсан ч Япон судлаачид, эрдэмтэн мэргэд, оюутнууд зэрэг үнэхээр олон монголчууд хүрэлцэн ирж оролцсонд миний бие монголчууд Япон орон, япончуудыг хичнээн их сонирхдог болохыг өөрийн биеэр мэдэрлээ” гэжээ. Элчин сайд мөн хоёр орны харилцаа маш сайн хөгжиж байгаа ялангуяа, сүүлийн арван жилийн туршид хоёр орны харилцаа иж бүрэн түншлэлийн хэмжээнд бүхий л салбарт хөгжиж байгааг дурдаад цаашид хоёр улсын харилцааг өргөн хүрээнд, гүнзгий хөгжүүлэхийн тулд хоёр орны ард иргэдийн харилцан ойлголцол юунаас илүү чухал гэдгийг онцолжээ. Гэвч одоогийн байдлаар Японы талд янз бүрийн мэдээ, мэдээлэл байгаа боловч Монголд Японы талаар гол гол мэдээлэл дутмаг байгаа, үүний тулд судлаач нар өөрсдийн салбарт Японы талаар судлах явдал маш чухал гэдгийг дурдаад Япон судлалыг хөгжүүлэхэд, мөн ард иргэдэд Японы тухай танилцуулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг уриалсан билээ.

Дараа нь “Монгол дахь Японы жил”-ийн зохион байгуулах Хорооны дарга, УИХ-ын гишүүн, Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын дарга С.Батболд үг хэлэв. Тэрээр мөн Монгол орны хөгжлийн болон Монгол, Японы хамтын ажиллагааны энэхүү шинэ зурвас үед судалгаа, мэдээлэл, төлөвлөлтийн ажлын хэрэгцээ шаардлага, ач холбогдол улам бүр өсч байгаа ба ийм цаг үед энэхүү симпозиум нь

\* Ж.Уянга - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Монгол дахь Япон судлал, түүнийг цаашид хөгжүүлэх асуудлыг хэлэлцэж байгаа нь нүдээ олсон арга хэмжээ гэж үнэлсэн юм.

Ерөнхий сайд асан Д.Содном тус симпозиумын үйл ажиллагаанд баяр хүргэж үг хэлэхдээ монголчууд бидэнд Япон улсын эдийн засаг, эм зүй, техник, мэдээллийн технологи, боловсролын систем, орон нутгийн хөгжил дэх бизнес эрхлэгчдийг дэмжин хэрэгжүүлж буй арга туршлагаас зайлшгүй суралцах зүйл их буйг тэмдэглэн хэлэв.

Түүнчлэн энэ симпозиум дээр манай нэрт эрдэмтэд, судлаачдын олон сонирхолтой илтгэлүүд тавигдсан билээ. ШУА-ийн Ерөнхийлөгч, академич Б.Чадраа, Ерөнхий сайд асан Д.Содном, Төрийн соёрхолт, академич Т.Намжим, ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн захирал, ШУ-ны доктор, профессор Л.Хайсандай, ГХЯ-ны Азийн газрын захирал, Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд С.Хүрэлбаатар, МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн захирал, доктор Ч.Хашчулуун, МУИС-ийн Гадаад хэл соёлын сургууль, доктор, профессор Т.Мөнхцэцэг, МУИС-ийн Гадаад хэл соёлын сургуулийн япон судлалын тэнхмийн эрхлэгч, доктор С.Долгор, ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор Б.Сэржав, Шинэ Монгол ахлах сургуулийн захирал, доктор Ж.Галбадрах, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал, ШУ-ны доктор, академич С.Нарангэрэл, Монгол Японы Соёл Утга Зохиолын Төвийн тэргүүн Д.Төмөрбаатар нар Япон судлалын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, тулгарч буй зорилтын талаар илтгэл тавьж хэлэлцүүлэв.

ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн захирал, ШУ-ны доктор, профессор Л.Хайсандай “Монгол дахь Япон судлал: өнөөгийн байдал, цаашдын төлөв хандлага” сэдвээр Монголд шинэ үеийн япон судлал бий болсон хүчин зүйл, өнөөгийн байдал, үүрэг холбогдол, цаашдын төлөв хандлагын талаар үндсэн илтгэл тавьсан билээ. Тэрээр 1980-аад оны сүүлээр Монгол Улсад өрнөсөн ардчилал шинэчлэлт нь манай улсын гадаад харилцааг үндсээр нь өөрчилж, олон тулгуурт нээлттэй бодлого хэрэгжиж эхэлснээр Монгол, Японы харилцаа шинэ үе шатанд дэвшин, эрчимтэй хөгжиж эхэлсэн, Монгол Улсын хөгжлийн шинэ гараатай хөл нийлүүлэн манай улс дахь япон судлал ч шинэ үе шатанд дэвшин, судалгааны ажлын цар хүрээ өмнөхөөс өргөжин тэлж, Япон дахь монгол судлалын зэрэгцээ Монгол, Японы харилцаа, Японы хөгжлийн туршлага, япон орон судлалын чиглэлд түлхүү хандах болсныг онцолсон билээ. Улс орны хөгжлийн эрх ашгийн үүднээс япон судлалыг гүнзгийрүүлж, жинхэнэ орон судлалын утгаар урагшлуулан хөгжүүлэх явдал япон судлаачдын өмнө тулгарч байгаа. Японы ард түмний соёл, зан заншил, нийгэм, эдийн засгийн түүхээс суралцаж, олон түмэнд бодит ойлголт өгөх, манай улсын хөгжилд

тусган авч, үр өгөөж өгөхүйц хэрэгтэй туршлагыг судлах, хоёр орны харилцааг ард түмний өргөн ойлголцол дээр хөгжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулах нь япон судлалын өнөөгийн зорилт болж байгааг онцлон тэмдэглэсэн.

Симпозиумын төгсгөлд хэлэлцүүлэг явагдаж симпозиумаас Япон улстай харилцах асуудал манай улсын гадаад бодлогын нэгэн тэргүүлэх чиглэл байж, хоёр орны харилцаа эдүгээ “иж бүрэн түншлэл”-ийн түвшинд хүрч амжилттай хэрэгжиж байгаатай уялдуулан Монгол дахь япон судлалыг эрчимжүүлэн, шинэ шатанд гаргах нь зүйтэй гэж үзээд цаашид хэрэгжүүлбэл зохих бодлого үйл ажиллагааны талаар зөвлөмж гаргасан юм. Үүнд:

1. Монгол Улсад Японы түүх, хэл, соёл, өнөөгийн нийгэм, улс төр, эдийн засаг, Монгол, Японы харилцаа, хамтын ажиллагаа зэрэг тал бүрийн сэдвээр хийгдэж ирсэн судалгаа шинжилгээний ажлыг улам бүр гүнзгийрүүлэх;

2. Японы улс төр, эдийн засгийн бодлого, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, бүтцийн өөрчлөлт, хөгжлийн арга туршлагыг тал бүрээс нь нухацтай судалж, судалгааны ажлыг Монгол Улсын нийгэм, эдийн засгийн өмнө тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх, улс орны хөгжлийг түргэтгэх асуудалтай уялдуулан судлах чиглэлийг баримтлах;

3. Монголын Япон судлаачдын Холбооны үйл ажиллагааг идэвхжүүлж, тогтмолжуулах. Үүнд:

- Монголын Япон судлалын оны хурлыг жил бүр хийх;

- Судлаачдын бүтээлийг нийтлүүлэх, харилцан мэдээлэл солилцох механизмыг бий болгох, Япон судлалын веб сайт, тогтмол сэтгүүлтэй болох;

- Гадаадын ижил төрлийн хүрээлэн, нийгэмлэгүүдтэй холбоо тогтоож, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

- Японы түүх, соёл, зан заншлын талаар цуврал бүтээлийг туурвиж хэвлүүлэх;

4. Япон судлалын мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх ажлыг эрчимжүүлэх. Япон судлалын ажилд дотоод гадаадын бизнесийн байгууллага, хувь хүмүүс, сангийн дэмжлэгийг олох талаар анхаарч ажиллах, мөн япон судлалыг эрчимжүүлэн чанаржуулахтай холбогдсон дээрх ажлуудыг хэрэгжүүлэхэд БСШУЯ, ГХЯ зэрэг холбогдох төр засгийн байгууллагуудын дэмжлэг туслалцааг авч ажиллах.

Төгсгөлд нь академич Ш.Бира симпозиумыг дүгнэж үг хэлэв. Тэрээр хэлсэн үгэндээ “Цаашид япон судлалыг уламжлалт чиглэлээр нь хөгжүүлэхийн зэрэгцээ хэрэглээний судалгааг эрс сайжруулахад анхаарлаа хандуулах нь зүйтэй” гээд япон судлал, монгол судлалыг хослуулан явуулах саналыг дэвшүүлсэн юм.

Түүнчлэн симпозиумын эмхэтгэлийг хэвлүүлж өргөн олон уншигчдадаа толилуулахаар болсон юм. Энэхүү эмхэтгэл нь Япон орон судлалын сургалт судалгаа, Япон орны талаар танин мэдэхүйн ач холбогдолтой материал болж байгаагаараа онцлогтой юм.